



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/62

Биндэр сум

**Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,
тэмцэх зарим арга хэмжээний тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, 18.2.13, 18.2.14, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.14, Улсын Онцгой комиссын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хуурайшилтын “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах, ан агнах, байгалийн жамаар унасан бугын эвэр түүх, бусад үйл ажиллагааг тус тус хязгаарласугай.

2.Ойг тарьж ургуулах, нөхөн сэргээх, мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэх, ойн аж ахуйн арга хэмжээний сургалт, дадлагын үйл ажиллагаа зохион байгуулах иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдтэй түймрийн аюултай улиралд ажиллах хариуцлагын гэрээ байгуулан гал түймэр алдахгүй баталгааг гаргуулсны үндсэн дээр ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг “Биндэр-Ой” сум дундын Ойн ангийн дарга (О.Сүхбат), байгаль хамгаалагч нарт даалгасугай.

3.Хуурайшилтын зэрэг, цаг агаарын төлөв байдлын мэдээг урьдчилсан болон нарийвчилсан байдлаар бэлтгэх, Цаг агаарын болон ой хээрийн түймрийн голомт тархалтын зураг, хуурайшилтын мэдээг тухай бүр шуурхай боловсруулж мэдээлэх, иргэдэд хавар, намрын хуурайшилтын зэрэг цаг агаарын мэдээг хэвлэл мэдээлэл болон бүх төрлийн цахим орчин ашиглан шуурхай хүргэж ажиллахыг “Биндэр Цаг Уур Өртөө”-ний дарга (Г.Энхмаа)-д үүрэг болгосугай.

4.Ой хээрийн бүсэд ил задгай гал түлэхгүй байх, зайлшгүй шаардлагаар түлсэн гал, түүний цог нурам, асаасан чүдэнз, татсан тамхины галыг бүрэн унтраах, эзэмшиж буй тээврийн хэрэгслийн бүрэн байдлыг хангасны үндсэн дээр ой, хээрийн бүсэд зорчих, хүн нэг бүрийн хамгаалах, гал түймэр унтраах багаж хэрэгслийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нийт иргэд, малчид, тариаланчид, тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт даалгасугай.

5.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааг сайтар зохион байгуулж, түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах зохион байгуулалтын ажлыг урьдчилан төлөвлөж ажиллахыг багийн Засаг дарга нар, байгаль хамгаалагчдад даалгасугай.

6.Ой хээрийн түймрийн аюултай улиралд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган бүрэн бус буюу яндангийн оч баригчгүй, түймэр унтраах багаж хэрэгсэлгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авахыг Биндэр сумын сум дундын цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Б.Ханхүү) -д даалгасугай.

7.Ойн арчилгаа цэвэрлэгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх, тээвэрлэх ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдэд түймрийн аюултай улиралд ажиллах хариуцлагын гэрээ байгуулан гал түймэр алдахгүй баталгааг гаргуулсны үндсэн дээр ойгоос мод бэлтгэх, байгалийн дагалт баялаг ашиглах зөвшөөрөл олгон байнгын хяналт тавьж ажиллахыг “Биндэр-Ой” сум дундын Ойн ангийн дарга (О.Сүхбат)-д үүрэг болгосугай.

8.Хөдөлгөөнт эргүүл харуул томилон ажиллуулж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулан иргэд, малчид, тариаланч, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага бүртэй хариуцлагын гэрээ байгуулан баталгаа гаргуулан ажиллахыг багийн Засаг дарга нар, байгаль хамгаалагч, “Биндэр-Ой” сум дундын Ойн ангийн дарга (О.Сүхбат), Хөдөө аж ахуйн тасгийн дарга (А.Гэрэлмаа), Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Х.Гэлэгжамц), нөхөрлөлүүдийн холбооны тэргүүлэгч (Б.Одончимэг) нарт, захирамжийн болон Байгаль орчныг хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Өнөболд), Байгаль хамгаалагч нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц. ДЭМБЭРЭЛСАЙХАН